

Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны
даргын хамтарсан 2013 оны 07 дугаар сарын 25-ны
өдрийн А/167/203 дугаар тушаалын хавсралт

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГИЙН БАГЦЫГ ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙЖ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь үл хөдлөх хөрөнгийн барьцаа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд уг хөрөнгийн багцыг бүрдүүлж буй үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан тухай тусгай тэмдэглэл /цаашид “тусгай тэмдэглэл” гэх/ хийж, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

1.2. Энэхүү журмын 1.1-д заасан тусгай тэмдэглэлийг хийхэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 397 дугаар тогтоолоор баталсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх” журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

ХОЁР. ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД БАРЬЦААНЫ ТУХАЙ ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙХ

2.1. Тусгай тэмдэглэлийг хийхэд улсын бүртгэгч нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.4-т заасныг тус тус баримтлан эрхийн улсын бүртгэлд бүртгэнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

2.2. Эрх шилжүүлэн авч байгаа этгээд /цаашид “тусгай зориулалтын компани” гэх/ нь тусгай тэмдэглэл хийлгэх тухай хүсэлтийг Хорооны шийдвэрийг үндэслэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн байгууллагад цаасан эсхүл цахим хэлбэрээр гаргах бөгөөд уг хүсэлтэд дараах баримт, материалыг хавсаргана:

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

2.2.1. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн тухай Хорооны шийдвэр.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

2.2.2. Хороонд бүртгүүлсэн хөрөнгийн багц дахь үл хөдлөх хөрөнгийн жагсаалт;

2.2.3. хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн гэрээ;

2.2.4. тусгай зориулалтын компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

2.3. Улсын бүртгэгч нь энэ журмын 2.2-т заасан хүсэлт, холбогдох баримт, материалыг хүлээн авч тухайн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хувийн хэрэгт хавсаргаж бүртгэнэ.

2.4. Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмших эрхийн гэрчилгээнд тусгай тэмдэглэл хийхдээ энэ журмын 2.2-т заасан хүсэлт, холбогдох баримт, материалыг хүлээн авч газрын кадастрын мэдээллийн системд тухайн эзэмшил газрын мэдээлэлд тусгай тэмдэглэл хийнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор нэмсэн./*

2.5. Улсын бүртгэгч бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд уг тэмдэглэл хийгдсэн бол энэ талаар хүсэлт ирүүлсэн этгээдэд хариу албан бичгээр мэдэгдэнэ.

*/Энэ хэсгийн заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

2.6. Тэмдэглэлийг улсын бүртгэлд бүртгэхэд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.5-д зааснаар үйлчилгээний хөлс авахгүй.

*/Энэ хэсгийн заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

2.7. Тусгай зориулалтын компани шаардлагатай бол зөвхөн өөрийн хүсэлтээр бүртгүүлсэн тусгай тэмдэглэлд, мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-д зааснаар бусад дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.

*/Энэ хэсгийн заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

ГУРАВ. ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД ХИЙГДЭХ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

3.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцтай холбоотой тусгай тэмдэглэлийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.4-т заасны дагуу хийнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

3.2. Газар эзэмших гэрчилгээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцтай холбоотой тусгай тэмдэглэлийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.4-т заасны дагуу хийхдээ газрын кадастрын мэдээллийн системд тусгай тэмдэглэл хийж “тусгай тэмдэглэл” гэсэн бүртгэл үүсгэнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор нэмсэн./*

3.3.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан үүрэг гүйцэтгэгчийн үүрэг дуусгавар болж, тусгай зориулалтын компаниас тусгай тэмдэглэлийг хүчингүй болгох хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд энэ журамд заасан тусгай тэмдэглэлд зөвхөн Хорооны шийдвэрээр өөрчлөлт оруулна.

3.4.Энэ журмын 3.3-т зааснаар тусгай зориулалтын компани тусгай тэмдэглэлийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан бол энэ тухай эрхийн улсын бүртгэлийг хөтөлж, тусгай тэмдэглэлд өөрчлөлт оруулан, дуусгавар болгоно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны *** дугаар тогтоолоор өөрчилсөн./*

---oOo---